

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр
төлөвлөсөн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалт, хяналтыг
хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн
төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН КОД: ДОА-2024/29-3-ШТА-ГА

Чойбалсан хот 2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatars@audit.gov.mn
Аудитор Г.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёог.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5

БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Авто замын тухай хуультай нийцүүлэн төлөвлөөгүй байна.....

А.1.1. Төсөл, арга хэмжээ нь аймгийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.....	6-7
А.1.2. Төсөл, арга хэмжээг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн төлөвлөсөн байна.....	6
А.2.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсвөө батлуулсан төсөл, арга хэмжээг тусгасан боловч 2 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг тусгай зөвшөөрөлгүй ААН гүйцэтгэсэн байна.....	6-7
А.2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримталсан байна.....	7

БҮЛЭГ Б. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад зохиогч, захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.....

Б.1.1 Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан байна.....	7
Б.1.2 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу шалгаруулсан байна.....	7-8
Б.2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн байна.....	8
Б.2.2. Хөрөнгө оруулалтын "ТЭЗҮ, зураг төсөв" ангилалд тусгагдсан төсөл, арга хэмжээ байхгүй байна.....	8
Б.2.3. Он дамжсан 311.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Ламжавын гудамжны авто замын засвар /Хэрлэн сум 2, 3-р баг/" төсөл, арга хэмжээ байна.....	8-9
Б.3.1. АИТХ-аас 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу төлөвлөөгүй, 1 төсөл арга хэмжээний санхүүжилтийг гэрээний дагуу олгоогүй байна.....	9
Б.3.2. Төсөл, арга хэмжээний нэмэлт гэрээ нь хуульд нийцсэн байна.....	10
Б.4.1 Эрх бүхий мэргэжлийн байгууллагын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих авто зам, замын байгууламжийн барилгын техник технологийн хяналт хэрэгжээгүй байна.....	10
Б.4.2. Зарим ажилд захиалагч, зохиогчийн хяналтыг тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээд гүйцэтгэсэн байна.....	10-11
Б.4.3. ТЕЗ-ийн дотоод хяналт үр дүнтэй хэрэгжсэн байна.....	11
Б.4.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.....	11
Б.5.1. Төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.....	12
Б.5.2. Төсөл арга хэмжээний гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг тооцсон байна.....	12-13
Б.5.3. Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна.....	13-14

ДҮГНЭЛТ:.....	14
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:.....	15
ЗӨВЛӨМЖ:.....	16
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	17

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
БГБХН	Бүх гишүүдийн бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ДОА	Дорнод аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИЗБНХ	Инженер зохион байгуулагчдын нэгдсэн холбоо
НҮТББ	Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник-эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагналын аудит
MNS	Mongolian national standard

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ТАХ-ний гэрээний биелэлт, олгосон санхүүжилт	13

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162, “Аудитын сэдэв батлах тухай” А/100 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэнэ.
Аудитын хамарсан хүрээ	Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд: - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх; - Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитад Дорнод аймагт авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ болон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, захиалагч, зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэв.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар, Г.Ганбилэг нар төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайланг 10 дугаар сарын 04-ний өдөр Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Төсвийн тухай, Авто замын тухай хуультай нийцүүлэн төлөвлөөгүй байна.

А.1. Төсөл, арга хэмжээ нь аймгийн урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

А.1.1. Төсөл, арга хэмжээ нь аймгийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

Аймгийн урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт”, “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүд хамаарч байна.

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд 10 төсөл, арга хэмжээг 1,202.9 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.

А.1.2. Төсөл, арга хэмжээг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн төлөвлөсөн байна.

Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцүүлэн төлөвлөсөн байна.

А.2. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Авто замын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагатай нийцүүлэн төлөвлөөгүй байна.

А.2.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсвөө батлуулсан төсөл, арга хэмжээг тусгасан боловч 2 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг тусгай зөвшөөрөлгүй ААН гүйцэтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэж заасан байна.

Дорнод аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 10 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв батлуулах шаардлагатай 7 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 2021 онд 1 төсөл, арга хэмжээ, 2022 онд 3 төсөл, арга хэмжээ, 2023 онд 3 төсөл, арга хэмжээний зураг төсвийг тус тус батлуулсан байна.

Жагсаалтын 2.1.2¹, 2.1.3², 2.1.4³, 2.1.6⁴ дахь төсөл, арга хэмжээнүүдийн зураг төсвийг гэрээний дагуу хүлээлцсэн актыг үйлдэж холбогдох баримтад хавсаргаагүй байна.

Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Авто зам, замын байгууламжийн зураг төслийг захиалагчийн баталсан зургийн даалгаврын дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.” гэж заасан.

¹ 2.1.2. Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт Баян-уул сумаас ульхан боомт чиглэлийн автозамын засвар арчлалтын ажил багц²

² 2.1.3. Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт Хэрлэн сумаас Булган сумын чиглэлд 27 км авто замын арчлалт багц³

³ 2.1.4. Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт Хэрлэн сумын хатуу хучилттай авто замын засвар арчлалтын ажил багц⁴

⁴ 2.1.6. Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт Хэрлэн сумын 5-р багийн Дэхтээс эхлэн Модон гүүр хүртэл авто зам, Модон гүүрийг засварлах багц⁶

Гэтэл авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2.1.2 дахь 133.0 сая төгрөгийн төсөвтэй “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт Баян-уул сумаас Ульхан боомт чиглэлийн автозамын засвар арчлалтын ажил багц2”, 2.1.3 дахь 54.8 сая төгрөгийн төсөвтэй “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт Хэрлэн сумаас Булган сумын чиглэлд 27 км авто замын арчлалт багц3” төсөл, арга хэмжээнүүдийн зураг, төсвийг “ДОЗТ” БГБХН гүйцэтгэсэн боловч тус хуулийн этгээд нь авто замын зураг төсөв зохиох тусгай зөвшөөрөлгүй байна.

Цаашид хууль, журмын дагуу авто зам, авто замын их засварын ажлын зураг, төсвийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлага үүссэн байна.

А.2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримталсан байна.

Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-ийн “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална:” 13.1.4⁵, 13.1.5⁶, 13.1.6⁷ дахь журам, 13.3-ын “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:” 13.3.1⁸, 13.3.2⁹, 13.3.3¹⁰ дахь заалтуудыг мөрдөж ажилласан байна.

БҮЛЭГ Б. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад зохиогч, захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Б.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1 Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан байна.

Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 1,194.7 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна. Тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТХ болон Сангийн Сайдын тендерийн жишиг баримт бичиг батлах тухай тушаал, холбогдох бусад журмын дагуу боловсруулж батлуулсан байна.

Б.1.2 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу шалгаруулсан байна.

Сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжих 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, тендерийн урилгыг

⁵ 13.1.4. төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

⁶ 13.1.5. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх;

⁷ 13.1.6. улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил төрлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргахгүй байх;

⁸ 13.3.1. хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах;

⁹ 13.3.2. хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

¹⁰ 13.3.3. техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим систем болон өдөр тутмын сонинд зарлан мэдээлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 996.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт”-ын ажлыг 6 багц болгон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа төсөвт өртгийг нь үндэслэн нээлттэй тендер шалгаруулалтын журмыг ашигласан байна. Төсөл, арга хэмжээний 1, 4, 5 дахь багцын ажлын тендерийг 2 удаа зарласан ч сонгон шалгаруулалт амжилтгүй болж, хуулийн дагуу гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах аргыг ашигласан байна. Харин 198.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Авто замын засвар арчлалтын техник, технологийн тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээний тендерт нээлттэй тендер шалгаруулалтын журмыг ашигласан байна.

Үнэлгээний хороо нь 996.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний 6 багц ажил, 198.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний тендерт тус тус үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулсан байна.

Б.2. Өмнөх оноос шилжиж хэрэгжсэн 311.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ чанаргүй хийгдсэн байна.

Б.2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн байна.

Хөрөнгө оруулалтын 996.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалт” төсөл, арга хэмжээг 6 багц болгон тухайн ажлыг норм дүрэм, зураг төслийн дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Чойбалсан хотын ахуйн үйлчилгээний төвийн хойд талын таксины зогсоолын шинэчлэлт Багц-1 /Төсөвт өртөг 95.0 сая төгрөг/. Гэрээний хугацаанд зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн байна.
- Баян-Уул сумаас Ульхан боомт чиглэлийн авто замын засвар арчлалтын ажил /төсөвт өртөг 132.9 сая төгрөг/. Гэрээний хугацаанд зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн байна.
- Хэрлэн сумаас Булган сумын чиглэлд 27 км авто замын арчлалт Багц-3 /төсөвт өртөг 54.8 сая төгрөг/. Гэрээний хугацаанд зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн байна.
- Хэрлэн сумын хатуу хучилттай авто замын засвар арчлалтын ажил Багц-4 /төсөвт өртөг 380.3 сая төгрөг/. Гэрээний хугацаанд зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн байна.
- Хэрлэн сум, 11-р багийн хайрган хучилттай 0.56 км авто замын ажил Багц-5 /төсөвт өртөг 60.0 сая төгрөг/. Гэрээний хугацаанд зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн байна.
- Хэрлэн сумын 5-р багийн Дэхтээс эхлэн Модон гүүр хүртэл авто зам, Модон гүүрийг засварлах Багц-6 /төсөвт өртөг 273.6 сая төгрөг/ Зураг төсвийн дагуу хугацаанд хийгдсэн байна.

Б.2.2. Хөрөнгө оруулалтын "ТЭЗҮ, зураг төсөв" ангилалд тусгагдсан төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад “ТЭЗҮ, зураг төсөв”-ийн ангилалд төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна.

Б.2.3. Он дамжсан 311.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ламжавын гудамжны авто замын засвар /Хэрлэн сум 2, 3-р баг/” төсөл, арга хэмжээ байна.

Өмнөх оноос шилжсэн 311.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ламжавын гудамжны авто замын засвар /Хэрлэн сум 2, 3-р баг/” төсөл, арга хэмжээ байна. Тус ажлыг хүлээн авах ажлын хэсэг нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх,

үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын 5.4-д "Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар шинэчлэлтийн ажлыг дутуу буюу хууль тогтоомж, стандарт, норм, норматив, дүрэм, зураг төсөл, техникийн нөхцөл шаардлагыг зөрчиж чанаргүй хийсэн, барилгын ажлын явцад Захиалагч болон Зөвлөх, мэргэжлийн хяналтын байгууллагуудаас тавьсан шаардлага, дүгнэлтийг биелүүлээгүй тохиолдолд ашиглалтад авахаас татгалзана." гэсэн заалтыг үндэслэн ашиглалтад хүлээн авахаас татгалзаж, үлдэгдэл төлбөрийг олгохгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Аудитын явцад тухайн ажлын чанар, үр дүнг шалгах боломжгүй нөхцөл байдал бий болсон нь тухайн авто замыг улсын төсвийн эх үүсвэрээр дахин шинээр барьж байгаатай холбоотой байна.

Б.3. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгоогүй байна.

Б.3.1. АИТХ-аас 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу төлөвлөөгүй, 1 төсөл арга хэмжээний санхүүжилтийг гэрээний дагуу олгоогүй байна.

Авто замын тухай хуулийн 4.1.28¹¹, 24.3¹²-д улсын авто замын сангийн хөрөнгөөр улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлыг санхүүжүүлэх, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор батлагдсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын 3.5¹³, 3.5.1¹⁴, 3.5.2¹⁵-д авто замын сангийн тухайн жилийн төсвийг төлөвлөх, хуваарилахад баримтлах зарчмыг заасан. Мөн захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний тусгай нөхцөлийн 5.6¹⁶-д төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлийг үндэслэн олгох бөгөөд 60-аас дээш хувийн гүйцэтгэлийн санхүүжилтийг ажил гүйцэтгэсний дараа олгоно гэж тус тус заасан байна.

Аймгийн 2023 онд хэрэгжүүлсэн 54.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хэрлэн сумаас Булган сумын чиглэлд 27 км авто замын арчлалт" төсөл, арга хэмжээ нь улсын чанартай авто замын арчлалт, засварын ажил бөгөөд орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

АИТХ-аас авто замын сангийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлахдаа нийт санхүүжилтийн 80%-ийг буюу 956.7 сая төгрөгийг авто замын арчлалт, засварын ажилд, 20%-ийг буюу 238.0 сая төгрөгийг авто замын засвар арчлалтын техник, тоног төхөөрөмж, хөндлөнгийн хяналт хийх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардалд төлөвлөсөн байна.

Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжсэн 54.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хэрлэн сумаас Булган сумын чиглэлд 27 км авто замын арчлалтын ажил" төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гэрээний тусгай нөхцөлийн 5.6-д заасан нөхцөлийг зөрчиж 46.3 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 84.4%-ийг гүйцэтгэлийн явцад олгосон байна.

¹¹ "улсын чанартай авто зам" гэж нийслэлийг аймгийн төвтэй, аймгийн төвийг хооронд нь болон хилийн боомттой холбосон авто замыг,

¹² улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ

¹³ авто замын сангийн тухайн жилийн төсвийг төлөвлөх, хуваарилахад дараах зарчмыг баримтална,

¹⁴ төсвийн 90-ээс багагүй хувийг Авто замын тухай хуулийн 24.3, 24.4-т тус тус заасан үйл ажиллагаанд,

¹⁵ төсвийн 10 хүртэлх хувийг Авто замын тухай хуулийн 24.5-д заасан үйл ажиллагаанд

¹⁶ санхүүжилтийг ажлын явц дунд 30 болон 60-н хувь хүртэл гүйцэтгэлийг үндэслэн олгох бөгөөд түүнээс дээш хувийн гүйцэтгэлийн санхүүжилтийг ажил гүйцэтгэсний дараа олгоно.

Цаашид авто замын сангийн хөрөнгийг журмын дагуу төлөвлөж, төсөл арга хэмжээний санхүүжилтийг гэрээний дагуу олгож, алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх шаардлагатай байна.

Б.3.2. Төсөл, арга хэмжээний нэмэлт гэрээ нь хуульд нийцсэн байна.

Төсөл, арга хэмжээ хэрэгжих хугацаанд жагсаалтын 2.1.6-д батлагдсан “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт төсөл, арга хэмжээний ажлын 6 дугаар багц” буюу Хэрлэн сумын 5-р багийн Дэхтээс эхлэн модон гүүр хүртэл авто зам, модон гүүрийг засварлах ажлын гэрээг 1 удаа сунгасан байна.

Нэмэлт гэрээ байгуулахдаа хур бороо орсны улмаас усны түвшин нэмэгдэн ажлын талбайд ажил гүйцэтгэх боломжгүй болсон шалтгаан нь ГЕН-ийн 4.5-ын “Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлтийг гаргаж болно:” 4.5.1 дэх “Ажлын гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.” гэсэн гэрээний заалтыг баримталсан байна.

Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй байна.

Б.4.1 Эрх бүхий мэргэжлийн байгууллагын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих авто зам, замын байгууламжийн барилгын техник технологийн хяналт хэрэгжээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагч талыг төлөөлж Дорнод аймгийн Ерөнхий архитектор, зураг төсөл зохиогч аж ахуйн нэгжүүд тус бүр зохих үе шатны ажлыг хянаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар холбогдох үүрэг даалгавар, заавар, зөвлөмжийг өгч ажилласан байна.

Харин аймгийн 2023 оны төсвийн нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 2.3.1 дэх заалтад тусгагдсан “Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт, шинэчлэлт, авто зам барих ажлуудад хөндлөнгийн хяналт хийх” ажлыг захиалагч ажлын даалгавар боловсруулж, Дорнод аймгийн “Инженер зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо” НҮТББ-тай гэрээ байгуулж, хөндлөнгийн хяналтыг хийлгэсэн байна.

Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын 1.2-д “Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх замын барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээг заавал хэрэгжүүлэх бөгөөд энэхүү журмыг баримтална.” гэж заасан байхад захиалагч тал хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь авто замын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулаагүйтэй холбоотой байна.

Б.4.2. Зарим ажилд захиалагч, зохиогчийн хяналтыг тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээд гүйцэтгэсэн байна.

Авто замын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6-д “Авто зам, замын байгууламжийн их засварын ажлын техник, технологийн хяналтыг тусгай зөвшөөрөл

бүхий этгээдүүдээс сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.” гэж заасан байна.

Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлсэн 6 төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ гүйцэтгэсэн байна. Цаашид захиалагчийн хяналтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

Зохиогчийн хяналтыг зураг төсөв зохиогч буюу “ХЗТ Авто зам” ХХК, “Гео зураглал” ХХК, “ДОЗТ” БГБХН зэрэг хуулийн этгээд гүйцэтгэсэн байна. Үүнээс “ДОЗТ” БГБХН нь хуульд заасан техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээд байна. Цаашид авто зам, замын байгууламж, их засварын ажилд тавих хяналтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, хэрэгжилтийг хангуулах шаардлага үүссэн байна.

Б.4.3. ТЕЗ-ийн дотоод хяналт үр дүнтэй хэрэгжсэн байна.

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6¹⁷, 14.2.10¹⁸, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-нд тус тус захиалагч нь гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих талаар заасан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2023 онд авто замын сангийн 2022-2023 оны хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна. Аудитаар хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой алдаа, зөрчлийг илрүүлж холбогдох байгууллага албан тушаалтанд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Цаашид төсөв захирагч нар дотоод аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, өгсөн зөвлөмжийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Б.4.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.7¹⁹, 6.3.8²⁰, 6.9²¹ дахь заалтуудаар шилэн дансны www.shilendans.gov.mn цахим сайтад байршуулах, цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.1.8²²-д цахим системээр дамжуулан гүйцэтгэх, хэрэгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах талаар тусгайлан зааж өгсөн байна.

¹⁷ төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих.

¹⁸ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

¹⁹ орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна

²⁰ тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт

²¹ “...3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ...

²² төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, тайлагналтыг цахим системээр дамжуулан гүйцэтгэх, хэрэгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах

“Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт, шинэчлэлт, авто зам барих ажлуудад хөндлөнгийн хяналт хийх” ажлыг гүйцэтгэсэн “Инженер зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо” НҮТББ нь авто замын сангийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг мэдээллийн самбарт байршуулаагүй байна.

Цаашид авто замын сангийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, санхүүжилт, гүйцэтгэлийн мэдээллийг мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй ил тод мэдээллэх, шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулах шаардлагатай байна.

Б.5. Төсөл арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Б.5.1. Төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.1.12²³ дахь заалт, Зам тээвэр хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1²⁴ дахь заалтуудад тус тус төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн бүрэн, үнэн зөв бүрдүүлэх, ажлын хэсгийн дүгнэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, гарсан зөрчил дутагдлыг бүрэн арилгах талаар тус тус заасан. Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн нийт 125.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээнд хүлээн авах комиссоос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Тухайлбал:

1. “Авто замын засвар арчлалтын техник, тоног төхөөрөмж” нийлүүлэх /65.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ төсөл, арга хэмжээнд запас дугуй олгох, номерын лавлагаа хавсаргах,

2. “Хэрлэн сумын 11 дүгээр багийн хайрган хучилттай 0.56 км авто зам” төсөл, арга хэмжээнд /60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ төсөл, арга хэмжээнд ажлаас үлдсэн ойр орчимд байгаа том чулууг цэвэрлэх, ховил дугуйн мөрийг засварлах зэрэг тус тус үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн нь нотлогдохгүй байна.

Цаашид ашиглалтад оруулах комисс үүрэг даалгаврын биелэлтийг хянаж баталгаажуулсны үндсэн дээр хүлээж авах шаардлагатай байна.

Б.5.2. Төсөл арга хэмжээний гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг тооцсон байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах,

²³ төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн бүрэн, үнэн зөв бүрдүүлэх

²⁴ авто зам, замын байгууламжийг зураг төсөл, стандарт, норм норматив, техникийн шаардлагын дагуу чанартай гүйцэтгэж, ажлын хэсгийн дүгнэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, гарсан зөрчил дутагдлыг бүрэн арилгана

тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.8.29²⁵-д төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх талаар заасан.

Төсөл, арга хэмжээний хүрээнд “Чандмань тал” ХХК, “Тэгш уудам харгуй” ХХК, “Ашид арвижих авай” ХХК-тай байгуулсан гэрээний биелэлтийг 100 хувь гэж дүгнэн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

“Хайду ажур” ХХК-тай байгуулсан гэрээний биелэлтийг 62 хувьтай дүгнэж санхүүжилтийн 62 хувийг олгосон байна. Инженер зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо НҮТББ-тай байгуулсан “Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт, шинэчлэлт, авто зам барих ажлуудад хөндлөнгийн хяналт хийх” төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж, гэрээний биелэлтийг 86.4 хувьтай дүгнэж, санхүүжилтийн 86.4 хувийг олгосон байна.

Хүснэгт 1. “ТАХ-ний гэрээний биелэлт, олгосон санхүүжилт”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Төсөвт өртөг /мян.төг/	Гэрээний биелэлт /хувь/
1	Хэрлэн сумын 5-р багийн Дэхтээс эхлэн Модон гүүр хүртэл авто зам, Модон гүүрийг засварлах	Чандмань тал ХХК	273,593.8	100
2	Баян-Уул сумаас Ульхан боомт чиглэлийн автозамын засвар арчлалтын ажил	Чандмань тал ХХК	132,983.2	100
3	Хэрлэн сумаас Булган сумын чиглэлд 27 км авто замын арчлалт	Чандмань тал ХХК	54,826.3	100
4	Хэрлэн сумын хатуу хучилттай авто замын засвар арчлалтын ажил	Тэгш уудам харгуй ХХК	245,109.3	100
5	Хэрлэн сум 11-р багийн хайрган хучилттай 0.56 км авто замын ажил	Тэгш уудам харгуй ХХК	60,000.0	100
6	Чойбалсан хотын ахуйн үйлчилгээний төвийн хойд талын таксины зогсоолын шинэчлэлт	Тэгш уудам харгуй ХХК	95,000.0	100
7	Авто замын засвар арчлалтын техник, тоног төхөөрөмж	Хайду ажур ХХК	191,400.0	62
8	Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт, шинэчлэлт, авто зам барих ажлуудад хөндлөнгийн хяналт хийх	ИЗБНХолбоо	20,000.0	86.4
9	Авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал	Ашид арвижих авай ХХК	19,900.0	100

Эх үүсвэр: Аудиторын ажлын баримт

Б.5.3. Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2²⁶, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.16²⁷-д төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг санхүүгийн тайлан, бүртгэлд тусгахаар тус тус заасны дагуу авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна. Үүнд:

Хэрлэн сумын ЗДТГ: 673.7 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ

1. “Хэрлэн сумын 5-р багийн Дэхтээс эхлэн Модон гүүр хүртэл авто зам Модон гүүрийг засварлах ажил”
2. “Хэрлэн сумын хатуу хучилттай авто замын засвар арчлалтын ажил”
3. “Чойбалсан хотын ахуйн үйлчилгээний төвийн хойд талын таксины зогсоолын шинэчлэлт”
4. “Хэрлэн сум 11-р багийн хайрган хучилттай 0.56 км авто замын ажил”

Баян-Уул сумын ЗДТГ: 132.9 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ

²⁵ төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маяг”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ

²⁶ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

²⁷ төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна

1. “Баян-Уул сумаас Ульхан боомт чиглэлийн автозамын засвар арчлалтын ажил”

Булган сумын ЗДТГ: 54.8 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ

1. “Хэрлэн сумаас Булган сумын чиглэлд 27 км авто замын арчлалтын ажил”

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ: 191.4 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ

1. “Авто замын засвар арчлалтын техник, тоног төхөөрөмж”

Аймгийн ЗДТГ: 19.9 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ

1. “Авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал” төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон дохионы төхөөрөмж

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг аймгийн урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн нь төлөвлөлтийн эхний шаардлагыг хангаж байна.
2. Худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу шалгаруулсан байна.
3. Төсвийн тухай хуулийн 29.4-д заасан зураг, төсвөө батлуулсан төсөл, арга хэмжээг батлуулсан боловч 187.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг Авто замын тухай хуулийн 19.1-д зааснаар авто зам, авто замын байгууламжийн зураг төсөв зохиох тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн нь хууль, журмын шаардлагыг хангаж ажиллахгүй байгаатай холбоотой байна.
4. Шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн байна. Харин өмнөх оноос шилжиж хэрэгжсэн 311.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ чанаргүй хийгдэж, комисс хүлээж аваагүй байна. Тус ажлыг 2024 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр барьж байгаа бөгөөд захиалагч байгууллагын уялдаа холбоо дутмаг байгаагаас авто замын сангийн хөрөнгийг үр ашиггүй төсөл, арга хэмжээнд зарцуулжээ.
5. Хууль, журмыг мөрдөж ажиллаагүйгээс шалтгаалан 1 төсөл арга хэмжээний санхүүжилтийг гэрээний тусгай нөхцөлийн дагуу олгоогүй байна.
6. Зохиогч, захиалагчийн хяналтыг мэргэжлийн, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэхгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.
7. Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн 2 төсөл, арга хэмжээнд комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байгаа тул цаашид анхаарах асуудал болж байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:



МОНГОЛ УЛС ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4202, факс: 7058-4584
Цахим шуудан: azdtg@domod.gov.mn
Цахим хуудас: Domod.gov.mn

Я. Зоригт:
Аудиторын тайлан
архив баталсан
хуульч.

2024.10.16 № 1/1980

танай _____-ны № _____-т

8/16
Б.Болортуул

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Цаашид төрийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

ЗАСАГ ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ

212407505

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргад зөвлөж байна. Үүнд:

1. Цаашид төсөл, арга хэмжээний зураг, төсвийг гэрээний хугацаанд гүйцэтгэж, батлуулж буй эсэхэд хяналт тавьж, батлагдсан зураг төсөв, хүлээлцсэн акт зэргийг төлөвлөлт, гүйцэтгэлийн баримтад хавсаргаж, иж бүрдлийг хангуулах.
2. Он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж орон нутагт үр дүн, үр ашгаа өгөхгүй хөрөнгө оруулалтыг төлөвлөхгүй байх.
3. Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, санхүүжилт, гүйцэтгэлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт хуулийн хугацаанд байршуулан иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж ажиллах.
4. Төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулахдаа үүрэг даалгаврын биелэлтийг бодитойгоор үнэлж, хянаж баталгаажуулсны үндсэн дээр бүрэн хүлээж авахыг комиссын гишүүдэд үүрэг болгох.

Аудитаар нийт 187.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн зөрчил арилгуулах 187.8 сая төгрөгийн 2 албан шаардлага, 4 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар тавигдсан албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Анхаарах зүйл: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг **аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор** төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.



ДӨРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 1/62

Чоймбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Я.Зориг)-т даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010173

Албан шаардлагын жагсаалт



№	Байгууллагын нэр, албан тушаал	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /сая.төг/
1	Аймгийн Засаг дарга	ДОА-2024/29-3	Зөрчил арилгах тухай	187.8
2	Аймгийн Засаг дарга	ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	-
	Нийт дүн			187.8

—оОо—

